

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны
..... тоот албан бичгийн нэгдүгээр хавсралт

“АЛСЫН ХАРАА -2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

2025 .04.07-ны өдөр

Улаанбаатар хот

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв /сая төгрөг /	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)	Үнэлгээ
				Он	Түвшин			
Зорилт 1.4. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон нүүдлийн соёл иргэншил, Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгаа хийж, нийтийн хүртээл болгон хэвшиж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ.								
1.4.6.	Монгол хүний ёс суртахууны хэм хэмжээний талаарх судалгааг өргөжүүлэн хүүхэд залуус, төрийн албан хаагч, хууль, хүчний байгууллагын ажилтны ёс суртахууны нарийвчилсан судалгааг хийнэ.	1,2	-	-	-	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажилласан байна.	МУИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөртэй “Улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын 2025 оны төлөвлөгөө”-г нийт 13 арга хэмжээний хүрээнд боловсруулж, 2024.12.04-ний өдрийн хурлаар баталав. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах зорилгоор дуу, дүрс бүхий мэдээлэл бэлтгэж хийж, байгууллагын сайтад 2025.02.19-ний өдөр байршуулсан. 2."Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төв"-д ирүүлсэн албан	100%

						хаагчдын ёс зүйтэй холбогдолтой 6 гомдлын шийдвэрлэлтийг зохих журмын дагуу шийдвэрлэсэн эсэхэд хяналт тавин шалгаж, гомдлын шийдвэрлэлтийн байдалд дүгнэлт хийж, холбогдох албан тушаалтанд заавар чиглэлийг хүргүүлэхээр ажиллаж байна. 3. Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмыг баримтладаг, удирдлага, хамт олны эерэг хандлага, харилцаанд анхаардаг хамт олныг шалгаруулах зорилготой 2025 оны Ёс зүйтэй хамт олныг шалгаруулах удирдамжийг боловсруулах ажлын хүрээнд аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс саналыг авах ажлыг эхлүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 30 нэгжээс 13 нэгжээс холбогдох саналыг ирүүлсэн байна. Уг удирдамжийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан батлахаар ажиллаж байна. 4.Улсын бүртгэлийн байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдад зориулан сургалт зохион байгуулах Удирдамжийн дагуу 2025.01.06-ны өдөр 9 албан хаагч, 2025.03.24-ний өдөр 14 албан хаагч, нийт 23 албан хаагчдад “Төрийн албан хаагчийн харилцаа, төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн зөрчлийн хэлбэрүүд” сэдвээр тус хорооны гишүүн Э.Сувд-Эрдэнэ сургалт хийв. 5.Тайлант хугацаанд тус хороо нь ёс зүйн зөрчилтэй гэх 3 гомдол, 1 мэдээллийг хүлээн авч шийдвэрлэснээс 3 ёс зүйн зөрчилд тооцохгүй тухай дүгнэлтийг гаргасан бөгөөд 1 мэдээллийн хувьд сошиал буюу цахим орчинд гарсан мэдээллийг хүлээн авч	
--	--	--	--	--	--	--	--

							шалгасан нь ёс зүйн зөрчил гаргасан гэх албан хаагч тогтоогдохгүй, нотлогдоогүй тул тухайн мэдээлэлд дурдагдсан ХУД-ийн УБХ-т Зөвлөмж хүргүүлэн ажиллаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13.3.5-д заасны дагуу 2025 оны 1 дүгээр улиралд хийсэн ажлын тайланг Ёс зүйн хорооны 2024 оны 13 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх бүртгэлийн маягт”-ын хамт боловсруулж, 2025.03.25-ны өдрийн 9/4205 дугаартай албан бичгээр Ёс зүйн хороонд хүргүүлэв.	
Зорилт 7.4. Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.								
7.4.4.	Салбарын алба хаагчдын цалин, хөлсний нэмэгдлийг тухайн жилийн инфляцын өсөлт, өндөр хөгжилтэй орны ижил төрлийн байгууллагын түвшинд хүргэнэ.		-	-	-	Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалтны цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу төрийн захиргааны 1082 албан хаагчийн цалингийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн. Мөн тус тогтоолын 10 ,11 дүгээр хавсралтад дурдсан 181 төрийн үйлчилгээний албан тушаалтны цалингийн доод хэмжээг байгууллагын даргын 2025 оны Б/33 дугаар тушаалаар шинэчлэн тогтоосон. Төрийн албанд болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзан төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагыг хангасан 383 албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдүүлэх, 45 албан хаагчид шинээр олгуулах саналыг Төрийн албаны	100%

						салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ариунболдод 2025.02.06-ны өдрийн 02 дугаар дотоод албан бичгээр, хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх төрийн албаны салбар зөвлөлийн дарга Н.Мягмарт 2025.03.20-ны өдрийн 1/3936 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Санхүү, аж ахуйн хэлтсээс шаардагдах цалингийн төсвийг урьдчилсан байдлаар авсан.	
7.4.9.	Иргэний үнэмлэх, гадаад паспортын бичилт хийх үйлдвэрийг өргөтгөж, бэлдэц үйлдвэрлэх дотоодын үйлдвэр байгуулна.	10313.0	-	2022	3742.6	Иргэний үнэмлэх, гадаад паспортын бичилт хийх үйлдвэрийг өргөтгөсөн байна. Үндэсний энгийн гадаад паспортын бичилтийн үйлдвэрийн байрыг олон улсын стандартыг хангасан байдлаар засварлан тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулж 2022.10.01-ний өдрөөс ашиглалтад оруулсан. УБЕГ-ын даргын 2024 оны А/09 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо хуралдаж, Иргэний үнэмлэхийн бичилтийн үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай Иргэний үнэмлэхийн машин, дагалдах тоног төхөөрөмж, систем худалдан авах тендерийн урилгыг 2024.01.18-ны өдөр www.tender.gov.mn , www.burtgel.gov.mn сайтад тус тус байршуулж, “Смарт карт” ХХК-ийн тендерт шалгаран 2024/34 тоот гэрээ байгуулсан. Тухайн гэрээний дагуу нийлүүлсэн барааг УБЕГ-ын даргын 2024.04.09-ний өдрийн А/57 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн гишүүд акт үйлдэж, хүлээн авсан болно. Гэрээний гүйцэтгэл 100 хувь. Иргэний үнэмлэх бичилтийн үйлдвэрийн Datacard MX2100 хэвлэх төхөөрөмжид шинэ загварын NFC цахим үнэмлэхийн бэлдэц	100%

						ашиглан хэрэглээнд нэвтрүүлэх тохиргоо, туршин тестлэх ажил хийгдэж дууссан бөгөөд 2025.03.25-ны өдрийн байдлаар нийт 286,203 NFC цахим үнэмлэх хэвлэгдсэн байна. Тайлант хугацаанд гадаад паспорт авах 1,085,098 иргэний (энгийн гадаад паспорт авах 329,506, цахим гадаад паспорт авах 755,592) хүсэлтийг хүлээн авч олгосон байна. ТӨБЗГ-ын 2024.05.16-ны өдрийн 234 дүгээр тогтоолоор УБЕГ-ын хөрөнгөд бүртгэлтэй 43 нэр төрлийн 16.115,1 сая төгрөгийн үнэтэй хөрөнгийг “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨДХХК-ийн төрийн мэдлийн 51 хувьд тооцон хувь нийлүүлсэн хөрөнгө (дүрмийн сан)-д шилжүүлэх тогтоолын дагуу 2024.10.26-ны өдөр УБЕГ-ын дэргэдэх үндэсний энгийн гадаад паспортын бичилтийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, программ хангамж, улсын бүртгэлийн сүлжээг “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨДХХК-ийн тусгай зориулалт бүхий байранд нүүлгэн шилжүүлсэн.	
7.4.10	Бүртгэлийн байгууллагын мэдээллийн баазыг бэхжүүлэх, хадгалалтыг сайжруулах зорилгоор сүүлийн үеийн өндөр хүчин чадал бүхий сервер, тоног төхөөрөмжийг үе	680.0	-	-	678.8	Төног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн байна. БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-аас буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл”-ийн хүрээнд Бүртгэлийн байгууллагын мэдээллийн баазыг бэхжүүлэх, хадгалалтыг сайжруулах зорилгоор 260 терабайт хэмжээтэй хадгалах төхөөрөмж, 111 ширхэг вертуал машин, сервер, генератор, тог баригч, сүлжээний тоног төхөөрөмжийн 2022 онд худалдан авалт хийж түүний тасралтгүй, найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.	100%

	шаттайгаар шинэчилнэ.						Мөн Азийн хөгжлийн банктай 2023.10.17-ны өдөр байгуулсан “Сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах” техникийн туслалцааны төслийн Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд байгууллагын даргын 2024 оны А/188 дугаар тушаалаар байгуулагдсан “Тоног төхөөрөмж хүлээн авах ажлын хэсэг” 2025.02.07-ны өдөр төслийн нэгжээс 100 ширхэг техник, тоног төхөөрөмжийг (компьютер 50 ширхэг, принтер 25 ширхэг, сканер 25 ширхэг) хүлээн авсан.	
7.4.20	Улсын бүртгэлийн мэдээллийн сан газар зүйн өөр байршилд нөөц сантай болгоно.		-	-	-	Улсын бүртгэлийн цахим сангийн хэвийн ажиллагаа хангагдсан байна.	Үндэсний дата төв нь нөөц төвийг Дархан-Уул аймагт байгуулсан бөгөөд энэхүү төвд Улсын бүртгэлийн мэдээллийн сан байршиж байна. Тус нөөцийн төвд байрших Бүртгэлийн системийн нөөц төв байгуулахад нэн шаардлагатай тоног төхөөрөмж, лицензийн жагсаалт (ажлын даалгавар)-ыг боловсруулан “Ухаалаг засаг-2” төслийн нэгжид хүргүүлсэн бөгөөд зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар болон холбогдох баримт бичгийг ЦХХХЯ болон төсөл хэрэгжүүлэх нэгжид бэлтгэн хүргүүлсэн. “Дэлхийн банк”-аас төсөл хариуцсан эрх бүхий албан тушаалтнууд 2024 оны 02 дугаар сард Монгол улсад айлчлан ирсэн бөгөөд төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, үе шаттай хэрэгжүүлэх, цаг хугацааг тодорхой болгох зорилгоор төслөөс үр шим хүртэгч байгууллагуудын удирдлагатай хийсэн нэгдсэн уулзалт болон техникийн 2 удаагийн уулзалтад манай байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд оролцож уг төслийг	100%

							хэрэгжүүлэхтэй холбоотой санал бодлоо солилцсон.	
7.4.30	Хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэл, танилтын системийг нэвтрүүлнэ.	2400.0	-	2022	2398.8	Хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэл, танилтын системийг нэвтрүүлсэн байна.	Биеийн давхцахгүй өгөгдөл буюу AFIS технологийг нэвтрүүлэх тооцоо, судалгаа техникийн шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 2022.01.31-ний өдөр н-2022/23 тоот гэрээг байгуулан 3 сая иргэний биометрийн мэдээллийг /10 хурууны хээний дүрснүүд, фото зураг/ бүртгэх баталгаажуулах, таних, дамжуулах бүх боломжийг хангасан AFIS лицензийг хүлээн авч системд нэвтрүүлсэн. Биеийн давхцахгүй өгөгдөл /хурууны хээ/-ийг шинэ /виртуал/ сервер рүү шилжүүлэн хэвийн аюулгүй байдлыг ханган ажилласан.	100%
Дундаж үнэлгээ								100% буюу 5 оноо

--oOo--